

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр, Пүрэв гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-5
<hr/>	
1.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргад нэр дэвшүүлэх тухай	3-5

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Хууль зүйн байнгын хорооны 11 дүгээр сарын 30-ны өдөр  
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 39 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.*

*Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд, Ж.Сүхбаатар, Б.Энх-Амгалан;  
Тасалсан: Г.Амартүвшин, Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан, С.Бямбацогт, Ц.Сэргэлэн.*

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хуралдаанд оролцов.

***Нэг.Улсын Их Хурлаас ирүүлсэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар томилуулах саналыг хэлэлцэх***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргад нэр дэвшигч Д.Сүнжид оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар Дугарын Сүнжидийг томилуулах тухай саналыг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Д.Цогтбаатар:** Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар Дугарын Сүнжидийг томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 09 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 14 цаг 48 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим, 14 цаг 39 минут

### **ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Д.Цогтбаатар:** Байнгын хорооны эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Ирц 57,9 хувьтай байна.

Дамдины Цогтбаатар, Ширнэнбаньдын Адьяа, Дашдондогийн Ганбат, Борхүүгийн Дэлгэрсайхан, Лхагвын Мөнхбаатар, Цэндийн Мөнх-Оргил, Цэрэнжамцын Мөнхцэцэг, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Ням-Осорын Учрал, Баттөмөрийн Энхбаяр гэсэн гишүүд ирсэн тул ирц бүрдсэн байна.

Хэлэлцэх асуудал өнөөдөр нэг байгаа.

Монгол Улсын Их Хурлын даргаас ирүүлсэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргад нэр дэвшүүлэх тухай саналыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Монгол Улсын Их Хурлын даргаас ирүүлсэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргад нэр дэвшүүлэх саналыг хэлэлцье.**

Ингээд Улсын Их Хурлын дарга албан бичгээр санал ирүүлсэн байгаа. Улсын Их Хурлын даргад микрофонд өгье. Өөрийнхөө саналыг танилцуулна.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг болон Улсын Их Хурлын тухай хуулийн холбогдох заалтуудыг үндэслэн 14.1.15 дахь заалтуудыг үндэслэн Дугарын Сүнжидийг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар томилуулах саналыг Хууль зүйн байнгын хороонд танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлаар Хүний эрхийн Үндэсний Комиссын тайлан илтгэлийг хэлэлцэж, Улсын Их Хурлын тогтоолыг баталж, хүний эрхийн цогц реформыг хэрэгжүүлэх зорилтыг тавьсан. Хүний эрхийн цогц реформын хүрээнд бид хүний эрхийн тайлангуудыг хэлэлцдэг, ярилцдаг байхаас гадна хууль, эрх зүйн орчинд шинэчлэл хийж, бүхий л хуулиуд дээр үнэлэлт, дүгнэлт өгч, хүний эрхийг дээдэлсэн хууль зүйн шинэчлэлүүдийг хийх ийм зорилтыг тавьсан. Тэгээд аливаа хуулийг хэлэлцэхдээ хүний эрх төвтэй байх ийм үндэс суурийг суулгах шаардлагатай гэж үзсэн.

Гэвч хүний эрхийн асуудал яриа маань тунхаглалын шинж чанартай байж болохгүй. Тэгээд энэ нөхцөл байдалтай уялдуулж, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүдтэй уулзалт хийж ярилцсан. Эрх зүйн реформ хийхийн хүрээнд, гадаад дотоод мэдээллийнхээ урсгалыг нэг болгох хүрээнд, болох болохгүй асуудлыг цаг тухайд нь үнэн, худал 2-ыг мэдээлж байх энэ үүрэг чиглэлийнхээ хүрээнд, эрүүдэн шүүлттэй

тэмцэх механизмыг ажиллуулж байгаа арга барилын хүрээнд бид нар бас асууж саналыг нь сонссон.

Ингээд Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүдээс ротацын зарчмаар буюу энэ үйл ажиллагаа сайжиртал, жигдэртэл Хүний эрхийн Үндэсний Комиссын даргыг хэлэлцэж дэвшүүлдэг байх ийм санал санаачилгыг дэвшүүлсэн. Ингээд Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүдийн энэ саналыг үндэслээд Хүний эрхийн Үндэсний Комиссыг хуралдаж саналаа ирүүлэх хүсэлтийг тавьсан.

Ингээд Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүд хуралдаад тэгээд нөгөө хүний эрхийн энэ реформыг хэрэгжүүлэхэд манлайлал, шинэ эрч хүч хэрэгтэй байгааг харгалзаад энэ ротацын зарчмаар томилж өгье гэсэн саналыг хэлэлцээд ингээд Хүний эрхийн Үндэсний Комисс маань өөрөө хамтын удирдлагын байгууллага учраас Хүний эрхийн Үндэсний Комиссын даргыг бас өөрчилж Дугарын Сүнжидийг нэр дэвшүүлэх саналыг ирүүлсэн.

Ингээд Хүний эрхийн Үндэсний Комиссын хуралдааны энэ протокол, санаачилгыг үндэслээд, хүний эрхийн чиглэлээр хийж хэрэгжүүлэх ёстой реформ шаардлагыг үндэслээд, Дугарын Сүнжидийг Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар томилох саналыг хамтын удирдлагын байгууллага учраас энэ гишүүдийн санал нэгтэй шийдсэн 100 хувийн саналаар 5 гишүүн оролцоноос 1 нь өвчтэй байсан. Нийт 6 гишүүнтэй 5 гишүүний 100 хувийн саналаар ийм санал ирүүлснийг та бүхэнд танилцуулж байна.

Дугарын Сүнжид 1977 онд төрсөн. 1993 онд Өндөрхаан хотын 1 дүгээр сургуулийг төгссөн. 1994-98 онд Монгол улсын Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр суралцаж төгссөн. 98-99 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хууль зүйн ухааны магистр, 2000-2002 онд ХБНГУ-ын Людвиг Максимилианы

Их сургуульд олон улсын харьцуулсан эрх зүйн магистр, 2006-2009 онд ХБНГУ-ын Людвиг Максимилианы их сургуульд Хууль зүйн ухааны докторын зэргийг тус тус хамгаалсан.

2002-2003 онд ШУА-ийн Философи, социологи, хүний эрхийн хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвийн судлаачаар, 2003-2012 онд Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлийн гишүүн, өмгөөлөгчөөр, 2005-2012 онд “Хөгжлийн төлөө төв” ТББ-ын гүйцэтгэх захирлаар, 2009-2014 онд Хууль зүйн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргаар, 2014-2015 онд Хууль зүйн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргаар, 2015-2017 онд Ерөнхийлөгчийн Тамгын газар Швейцарын хөгжлийн агентлагийн Иргэдийн оролцоо төслийн зохицуулагчаар, 1998 оноос одоог хүртэл Удирдлагын академийн эрх зүйн тэнхимийн багш, ахлах багш, дэд профессор, 2017 оноос ХЗДХЯ ШУА-ийн хамтарсан иргэдийн оролцоо 2 төслийн зохицуулагчаар, 2020 оноос Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнээр ажиллаж байна.

Ийм эрх зүйн өндөр мэдлэг, боловсролтой, хүний эрх, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцооны чиглэлээр ажилласан энэ туршилагыг харгалзан үзэж, онол практикийн мэдлэгийг үндэслэн Хүний эрхийн Үндэсний Комиссын даргад нэр дэвшүүлж байгаа юм. Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

**Д.Цогтбаатар:** Их Хурлын даргад баярлалаа.

Ингээд нэр дэвшүүлэх саналтай холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү?

Байхгүй байна.

Ингээд нэр дэвшигчийн талаар асуулт асууж, үг хэлж дууслаа.

*Тэгэхээр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар Дугарын Сүнжидийг томилох нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.*

*54 хувийн саналаар санал дэмжигдлээ.*

*Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргыг томилох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж танилцуулна.*

*Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.*

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**П.ОЮУНГЭРЭЛ**